



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 09.

Хэргэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хурлын 09 дүгээр тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2021-2022 оны өвлийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлтийн тухай:

СОНССОН нь:

Компанийн 2021-2022 оны өвлийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний хүрээнд хөрөнгө оруулалтын ажлын биелэлт 92.3 хувь, их засварын ажлын биелэлт 94.3 хувь, техник зохион байгуулалтын арга хэмжээний биелэлт 88.9 хувь, өвлийн бэлтгэл ажлын биелэлт дунджаар 91.83 хувьтай байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай холбоотой улсын хэмжээнд тогтоосон хөл хорио, хил, гаалийн асуудлаас шалтгаалан зуух №2-ын их засварын ажлыг 2022 оны төлөвлөгөөнд тусгахаар хойшлуулсан байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Компанийн 2021-2022 оны өвлийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлж, хүндэрч болзошгүй тулгамдсан асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд тухай бүр танилцуулж, үйлдвэрлэлийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг ханган ажиллахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт үүрэг болгов” гэжээ.

ДАРГА  Ж.ЖАНАРБААТАР

ДОРНОД БҮСНИЙ
ЭРЧИМ ХҮЧНИЙ
СИСТЕМ
ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ
ТТР0374 - 2628051
ДОРНОД АУЛС-3

580019007



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 10

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хурлын 10 дугаар тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн “Авлигын эрсдлийн үнэлгээ”-ний дагуу хийгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан

СОНССОН нь:

Авлигатай тэмцэх газар, “Онч шийдэл” ТББ-аас хамтран хийсэн авлигын эрсдлийн үнэлгээний дагуу 22 төрлийн ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан мөрдөх, хэрэгжилтийг Авлигатай тэмцэх газарт тогтоосон хугацаанд тайлагнах, хариуцлагатай, ил тод, авлигын эрсдэл үүсгэхгүй ажиллахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт үүрэг болгов” гэжээ.

ДАРГА *Мандраг* Ж.ЖАНАРБААТАР

580019006



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 18

Хэрлэн сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх
хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэг, Компанийн дүрмийн 7.14 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийн төлөөлөл өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралт дахь “Аудитын хорооны гишүүн Г.Энхтүвшин” гэснийг “Аудитын хорооны гишүүн О.Бүжин” гэж, “Цалин, урамшууллын хорооны дарга Г.Энхтүвшин” гэснийг “Цалин урамшууллын хорооны дарга Г.Бадамцэцэг” гэж тус тус өөрчилсүгэй.

ДАРГА *Мансартсан* Ж.ЖАНАРБААТАР

580019020



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 19

Хэрлэн сум

Г

Г

Компанийн ажилтнуудын сарын үйл ажиллагааны
үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалин хөлс олгох журмын тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Компанийн дүрмийн 7.3.17 дахь заалт, Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт (тариф)-ын хэлэлцээрийн 3.6, 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний аудитын газар болон Эрчим хүчний яамнаас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд шинэчлэн боловсруулсан компанийн ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалин хөлс олгох журмын төслийг дэмжиж, холбогдох хууль тогтоомж, хамтын хэлэлцээрт нийцүүлэн шинэчлэн батлахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт зөвшөөрсүгэй.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цалин, урамшууллын хороо (Г.Бадамцэцэг)-нд үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ЖАНАРБААТАР
төлөөлөгч
удирдах
зөвлөл

580019017